БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2023/194/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Булган аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудит ХХК<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12

**3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа** ........ 12

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин** ........ 12

**3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал** ........ 13

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд** ........ 13

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 14

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14

**4.1 Ерөнхий зүйл** ........ 14

**4.2 Материаллаг байдал** ........ 15

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 15

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 16

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 16

**5.1 Төлбөрийн акт** ........ 16

**5.2 Албан шаардлага** ........ 16

**5.3 Зөвлөмж** ........ 16

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХҮЕГ | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аянчлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail.bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 118

танай ________________ ны № ________________ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Ахмадын амралтын орлогын төлөвлөгөөг 115,974.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 115,565.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нэгтгэн тайлагнах арга хэмжээний хүрээнд шинээр 1, түр 3-н ажлын байрыг бий болгосон байна.

**Аудитын гол асуудал**

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь 2022 онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар болон аймгийн Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 91.1 хувийн биелэлтэйгээр тайлагнасан.

00602012 8

2022 онд улсын төсвөөс 600,169.8 мянган, орон нутгийн төсвийн захирагчаас 8,000.0 мянган, туслах үйл ажиллагааны орлого 115,565.0 мянган, нэмэлт санхүүжилтээр 41,854.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд хувь хүнээс авах 1,500.0 мянган төгрөгийн авлагатай, цалингийн 4,853.2 мянган төгрөгийн өглөгтэй байснаас өглөгийг бүрэн, авлагыг 500.0 мянган төгрөгөөр барагдуулж, 1,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,441,763.00** | **55,925,738.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 99,995.00 | 8,000,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 99,995.00 | 8,000,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 1,500,000.00 | 1,000,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,500,000.00 | 1,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 39,841,768.00 | 46,925,738.20 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,055,310.00 | 1,055,310.00 |
| 35130 | Эм боох материал | 1,055,310.00 | 1,055,310.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 00.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,786,458.00 | 45,870,428.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 795,000.00 | 3,552,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,791,698.00 | 25,174,308.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,205,000.00 | 1,270,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,636,000.00 | 3,195,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 150,000.00 | 150,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 719,560.00 | 1,877,800.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,489,200.00 | 10,651,020.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,224,969,981.87** | **1,211,263,020.11** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 00.00 | 00.00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,224,969,981.87 | 1,211,263,020.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,084,872,981.87 | 1,071,221,020.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,174,100,261.39 | 1,171,310,928.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -208,506,064.53 | -225,220,716.57 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 137,530,630.00 | 108,730,630.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -137,530,630.00 | -98,530,630.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 184,700,435.07 | 129,391,188.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -110,997,384.77 | -52,646,978.75 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 84,207,604.00 | 74,765,379.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -38,631,869.29 | -38,545,447.19 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 00.00 | 2,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -33,333.33 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 140,097,000.00 | 140,042,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 00.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -245,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 140,042,000.00 | 140,042,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,266,411,744.87** | **1,267,188,758.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,853,214.18** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,853,214.18 | 00.00 |
| **411** | **Богино хугацаат үнэт цаас** | 00.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 4,853,214.18 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,853,214.18 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,261,558,530.69** | **1,267,188,758.31** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,261,558,530.69 | 1,267,188,758.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 418,151,929.90 | 418,151,929.90 |
| 51101 | Өмч:  - төрийн | 278,109,929.90 | 278,109,929.90 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 140,042,000.00 | 140,042,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 359,373,608.34 | 367,793,168.40 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 359,373,608.34 | 362,162,940.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 5,630,227.62 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 484,032,992.45 | 481,243,660.01 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,266,411,744.87** | **1,267,188,758.31** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **698,555,909.00** | **821,198,000.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **110** | **Орлогын албан татвар** | 00.00 | 00.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **70,544,031.00** | **171,173,320.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 56,014,576.00 | 171,173,320.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 17,455,576.00 | 56,108,320.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 00.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 14,529,455.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **628,011,878.00** | **650,024,680.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 612,061,500.00 | 600,169,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,061,500.00 | 600,169,800.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,950,378.00 | 41,854,880.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,450,378.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,500,000.00 | 41,854,880.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 8,000,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 8,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **766,422,162.25** | **815,567,772.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **766,422,162.25** | **815,567,772.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 722,253,891.80 | 774,313,295.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 449,539,777.00 | 444,046,868.75 |
| 210101 | Үндсэн цалин | 344,669,860.96 | 335,255,407.21 |
| 210102 | Нэмэгдэл | 90,842,403.38 | 59,257,734.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,027,512.66 | 12,424,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 37,109,726.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,485,817.23 | 55,787,468.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,639,317.28 | 38,838,355.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,626,518.90 | 4,569,785.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,628,096.32 | 3,376,885.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 871,989.82 | 818,403.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,719,894.91 | 8,184,038.13 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,884,282.00 | 52,719,349.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,574,660.00 | 5,717,676.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 28,479,192.00 | 38,032,316.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,830,430.00 | 8,969,357.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,442,273.00 | 17,592,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,974,588.00 | 2,967,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,810,350.00 | 4,988,940.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,464,650.00 | 1,890,850.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 410,000.00 | 404,180.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,875,980.00 | 3,086,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,906,705.00 | 4,254,390.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,341,225.00 | 45,047,683.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 501,450.00 | 25,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,627,225.00 | 42,273,953.80 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,212,550.00 | 2,747,780.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,604,200.00 | 10,297,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,771,000.00 | 1,166,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,833,200.00 | 9,130,750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,438,000.00 | 3,603,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,438,000.00 | 3,603,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38,017,069.50 | 74,956,112.76 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,674,778.50 | 69,674,667.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,632,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 635,175.00 | 672,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 139,600.00 | 160,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,400.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 194,600.00 | 429,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 306,516.00 | 310,923.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,501,248.07 | 70,263,261.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,529,455.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,971,793.07 | 70,263,261.76 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,168,270.45 | 41,254,476.89 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,484,200.00 | 5,031,995.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,044,200.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,440,000.00 | 5,031,995.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,684,070.45 | 28,781,502.89 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,684,070.45 | 28,781,502.89 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,440,979.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,440,979.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-67,866,253.25** | **5,630,227.62** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-67,866,253.25** | **5,630,227.62** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **666,570,878.00** | **765,589,680.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **38,559,000.00** | **115,565,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 38,559,000.00 | 115,565,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 38,559,000.00 | 115,565,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 00.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **628,011,878.00** | **650,024,680.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 612,061,500.00 | 600,169,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,061,500.00 | 600,169,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,950,378.00 | 41,854,880.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,450,378.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,500,000.00 | 41,854,880.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 8,000,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 8,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **661,374,938.00** | **756,099,675.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **661,374,938.00** | **756,099,675.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **617,206,667.55** | **714,845,198.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 444,371,562.82 | 448,900,082.93 |
| 210101 | Үндсэн цалин | 339,501,646.78 | 340,108,621.39 |
| 210102 | Нэмэгдэл | 90,842,403.38 | 59,257,734.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,027,512.66 | 12,424,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 21,852,377.58 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 15,257,349.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,485,817.23 | 55,787,468.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,639,317.28 | 38,838,355.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,626,518.90 | 4,569,785.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,628,096.32 | 3,376,885.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 871,989.82 | 818,403.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,719,894.91 | 8,184,038.13 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,872,282.00 | 56,175,149.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,574,660.00 | 5,717,676.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,467,192.00 | 41,488,116.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,830,430.00 | 8,969,357.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,980,716.00 | 14,339,840.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,185,096.00 | 3,613,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,328,000.00 | 5,555,920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,464,650.00 | 1,890,850.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 887,700.00 | 404,180.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,115,270.00 | 2,875,650.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,348,120.00 | 45,723,844.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 733,970.00 | 25,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,428,800.00 | 43,432,194.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,185,350.00 | 2,265,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,286,200.00 | 10,593,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,453,000.00 | 1,166,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,720,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,833,200.00 | 7,707,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,438,000.00 | 3,603,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,438,000.00 | 3,603,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,423,969.50 | 79,721,512.76 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,770,678.50 | 70,753,467.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,632,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 635,175.00 | 672,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 139,600.00 | 160,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,400.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 505,600.00 | 2,115,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 306,516.00 | 310,923.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 4,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,168,270.45** | **41,254,476.89** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,484,200.00 | 5,031,995.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,044,200.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,440,000.00 | 5,031,995.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,684,070.45 | 28,781,502.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,684,070.45 | 28,781,502.89 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,440,979.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,440,979.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,195,940.00** | **9,490,005.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,315,940.00** | **1,590,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,315,940.00** | **1,590,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,315,940.00 | 1,590,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-6,315,940.00** | **-1,590,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -1,120,000.00 | 7,900,005.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,219,995.00 | 99,995.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 99,995.00 | 8,000,000.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **484,032,992.45** | **359,373,608.34** | **1,261,558,530.69** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **484,032,992.45** | **359,373,608.34** | **1,261,558,530.69** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 2,789,332.44 | 2,789,332.44 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **418,151,929.90** | **484,032,992.45** | **362,162,940.78** | **1,264,347,863.13** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -2,789,332.44 | 00.00 | -2,789,332.44 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 5,630,227.62 | 5,630,227.62 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **481,243,660.01** | **367,793,168.40** | 1,267,188,758.31 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 716,143,800.00 | 715,834,795.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 716,143,800.00 | 715,834,795.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 711,211,700.00 | 682,021,297.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 451,875,300.00 | 429,919,279.93 |
| 210101 | Үндсэн цалин | 335,860,300.00 | 340,108,621.39 |
| 210102 | Нэмэгдэл | 96,234,800.00 | 59,257,734.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,780,200.00 | 12,424,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 18,128,923.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,844,500.00 | 53,543,790.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,093,700.00 | 36,838,355.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,687,700.00 | 4,326,107.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,750,200.00 | 3,376,885.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 937,500.00 | 818,403.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,375,400.00 | 8,184,038.13 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,258,800.00 | 56,175,149.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,839,700.00 | 5,717,676.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,806,400.00 | 41,488,116.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,612,700.00 | 8,969,357.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,695,700.00 | 8,690,420.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 842,900.00 | 1,619,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,444,300.00 | 2,400,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,437,000.00 | 1,390,850.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 495,000.00 | 404,180.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,476,500.00 | 2,875,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,723,900.00 | 45,723,844.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,000.00 | 25,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 43,432,200.00 | 43,432,194.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,265,700.00 | 2,265,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,215,600.00 | 11,193,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,766,300.00 | 1,766,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,739,400.00 | 1,720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,709,900.00 | 7,707,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 63,400.00 | 63,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 63,400.00 | 63,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 77,534,500.00 | 76,711,512.76 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 72,246,100.00 | 71,743,467.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,700,000.00 | 1,632,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 672,400.00 | 672,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 210,100.00 | 160,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 84,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,201,700.00 | 2,115,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 420,200.00 | 310,923.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4932100.00 | 5031995.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,932,100.00 | 5,031,995.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 716,143,800.00 | 715,734,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 600,169,800.00 | 600,169,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 600,169,800.00 | 600,169,800.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 115,974,000.00 | 115,565,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 115,974,000.00 | 115,565,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 99,995.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 8,000,000.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 34,413,901.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 34,413,901.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 34,413,901.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 18,980,803.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 3,723,454.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,257,349.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,243,678.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,000,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 243,678.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,649,420.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,993,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,155,920.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,540,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,000,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 |

| | | |
|---|---|---|
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 41854880.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 41,854,880.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,854,880.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь ахмадын амралтын орлогын төлөвлөгөөг 115,974.0 мянган төгрөгөөр баталснаас 115,565.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нэгтгэн тайлагнах арга хэмжээний хүрээнд шинээр 1, түр 3-н ажлын байрыг бий болгож 1 байнгын ажлын байрыг хадгалсан байна.

2022 онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар болон аймгийн Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 91.1 хувийн биелэлтэйгээр тайлагнасан.

2022 онд улсын төсвөөс 600,169.8 мянган, орон нутгийн төсвийн захирагчаас 8,000.0 мянган, туслах үйл ажиллагааны орлого 115,565.0 мянган, нэмэлт санхүүжилтээр 41,854.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд хувь хүнээс авах 1,500.0 мянган төгрөгийн авлагатай, цалингийн 4,853.2 мянган төгрөгийн өглөгтэй байснаас өглөгийг бүрэн, авлагыг 500.0 мянган төгрөгөөр барагдуулж, 1,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Ахмад настны тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. ХХҮГ-ын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/85 дугаар тушаалаар "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтын журам"-ыг батлуулан журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", дотоод журмын заалтыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ACOLOUS програм ашигладаг.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 777.0 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өсчээ.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 100.0 | 8,000.0 | 7,900.0 |
| Авлага | 1500.0 | 1,000.0 | -500.0 |
| Бараа материал | 39,841.8 | 46,925.7 | 7,083.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,224,969.9 | 1,211,263.0 | -13,706.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,266,411.7** | **1,267,188.7** | **777.0** |
| Өр төлбөр | | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,266,411.7 | 1,267,188.7 | 777.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,266,411.7** | **1,267,188.7** | **777.0** |

Хүснэгтээс дэх 2022 оныг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмнэлт болон бусад мөнгөн хөрөнгийн хэмнэлтээс мөнгөн хөрөнгө 7,900.0 мянган, хандиваар 132.0 мянган, шилжүүлэн авсан 1,010.0 мянга, аж ахуйн зориулалтаар худалдан авсан барааны үлдэгдэл нь бараа материалыг 7,083.9 мянган төгрөгөөр өсгөж, 4 дансны нийт 29,147.3 мянган төгрөгийн хөрөнгө актласан нь үндсэн хөрөнгийг 13,706.9 мянган, авлагаа 500.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслөө зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 630,2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос  197.9 сая, нийт зарлагыг 828.1 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 81.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 21.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 172.1 сая, үйл ажиллагааны орлогоос 36.5 сая төгрөгийг бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 99.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар

болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогын 716,143.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,742,1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эд хогшил, урсгал засварын зардлыг 56.3 хувь буюу 4,359.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйчилгээний зардлыг 13.0 хувь буюу 178.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус хэлтэс 2022 онд шилэн дансны сайтад нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн

байршуулснаар мэдээлсэн байна.Мэдээллүүдийг тулган шалгахад төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн тухай 2,139.4 мянган төгрөгийн 3 тушаалыг байршуулаагүй байна. Аудитын баг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2, 3.2.11 заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй гэсэн үндэслэлээр албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2022.6.24-ны 01/249 тоотоор зөвлөмжийн биелэлт Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 2 | 6,353.2 | 2 | 6,353.2 | 100,0 |
| **Нийт дүн** | **2** | **6,353.2** | **2** | **6,353.2** | 100,0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд алдаа илрээгүй боловч эрх зүйн акт зөрчигдсөн[1] 1 алдаанд дахин давтан гаргахгүй байхад зөвөмж өгөхөөр шийдвэрэсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар Шилэн дансны хууль, журмыг мөрдлөг болгон ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

#### 5.3.1 Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

***<u>Илрүүлэлт</u>:*** Тус газрын үндсэн хөрөнгө аймгийн Өмчийн газарт бүртгэлтэй байдаг. Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд дагаж мөрдөхөөр баталсан НБББББ-д үндсэн хөрөнгийг актлахдаа аймгийн ИТХ-ын 2014 оны 17 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх актлах журам"-ыг мөрдөхөөр тусгасан. Уг журмын 6.1.1-д: Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, түүх соёлын ховор, үнэт, дурсгалт зүйлээс бусад анх үнэ 3 сая төгрөгөөс доош орон нутгийн өмчит үндсэн хөрөнгийг сум, байгууллага бие дааж шийдвэрлэнэ." гэсний дагуу ХХҮГ-ын дарга 2022 оны А/73, 152 дугаар тушаалуудаар нийт 23 нэр төрлийн 29.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гаргаж, данснаас хасалт хийсэн. Санхүүгийн тайлан ХХҮЕГ-т нэгтгэгддэг ба 2018 оны НБББББ-ийн 5.2-т: "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд ТӨХ-ны шийдвэрээр данснаас хасна." гэсэн заалтыг мөрдлөг болгоогүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д: Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн эрх зүйн акт зөрчигдөх магадлалтай байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*****:** Эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 1 | 0,0 | 1 | 0,0 | | | | | | | 1 | |
| Дүн | 1 | 0.0 | | | | | 1 | | | | 1 | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 1 | 0.0 | | | 1 | 0.0 | | | | | | |
| Дүн | 1 | 0.0 | | | 1 | 0.0 | | | | | | |